

УЛС ТӨРИЙН АВТОРИТАР ДЭГЛЭМИЙН ЗАРИМ АСУУДАЛ

А. Жамбал

XX зууны II хагасыг бараг бүхэлд нь эзлэн үргэлжилж дэлхийн улс орон, үндэстэн ард түмнүүдийг хооронд нь сөргөлдүүлж тэмцэлдүүлсэн «хүйтэн дайн» эцэс төгсгөл боллоо. Үүний үрээр олон орны амьдралд тогтож хэвшсэн хуучин харилцаа, дэг журам, олон орны нийгмийн байгуулал, улс төрийн дэглэм үндсээрээ өөрчлөгдөж дэлхий нийтэд шинэ харилцаа, шинэ дэглэм журамд шилжих цаг үе, үйл явц эхлээд байна.

Улиран өнгөрч буй XX зуунд дэлхийн янз бүрийн улс орнуудад улс төрийн янз бүрийн дэглэм тогтон ноёрхож мөн зэрэг ба сөрөг янз бүрийн үүрэг зорилгыг гүйцэтгэжээ. Өрнөдийн хөгжилтэй, соёл иргэншилтэй олон улс төрийн ардчилсан, түүнчлэн аядуу либерал шинжтэй дэглэмийг сонгон тогтоож тэдгээрийн хүч нөлөө, хөшүүргийг ашиглаж эдийн засаг, нийгэм, улс төр, соёлоо төвхнүүлэн хөгжүүлж, хүн ардынхаа амьдралын түвшинг дээшлүүлж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж хэрэгжүүлэх, хангах талаар чамгүй амжилтанд хүрчээ.

Улс төрийн хамгийн хатуу хахир дэглэм болохоо харуулсан тоталитар дэглэм зүүн ба коммунист хэлбэртэйгээр хуучны ЗХУ тэргүүтэй социалист гэгдэж байсан арав гаруй оронд, баруун фашист, нацист хэлбэртэйгээр Герман, Итали оронд тогтон ноёрхож эдгээр улс орны нийгэм, эдийн засаг, улс төр, соёл-оюун санаанд, түүнчлэн олон улсын харилцаа, амьдралд ч ихээхэн балагтай хор уршгийг шарх сорви болон үлдээжээ.

Улс төрийн дээрхи дэглэмүүдийн зэрэгцээ **авторитаризм** хэмээн нэрлэгддэг дэглэм өрнө ба дорнын олон оронд урт богино янз бүрийн хугацаагаар тогтон ноёрхож сөрөг ба зэрэг, ээдрээ зөрчилтэй үүрэг гүйцэтгэж дэлхийн нэлээд оронд одоо ч гэсэн тогтсон хэвээр байна.

Хуучны социалист гэгдэж, тоталитар дэглэмийн нөлөө ноёрхолд байж түүнээс саяхан мултран салж хүн ард нь ардчилал, хүний эрх, эрх чөлөөг хүсэн тэмүүлж буй хэд хэдэн улс орон тоталитаризмаас ардчилсан дэглэмд биш харин гэдрэг ухарч авторитари дэглэмд орох төлөв хандлага ашиглагдаж байна. Монгол улс тоталитар дэглэмээс ангижран салж зах зээлийн эдийн засаг, улс төрийн ардчилал олон эшт үзэл суртал, үзэл бодлын зарчмыг сонгон авч хуульчлан баталгаажуулж бодитойгоор хэрэгжүүлэх алхам, оролдлогыг хийж байгаа ч гэсэн дорвитой ахиц олселтонд хүрээгүй, ихээхэн бэрхшээл, ноцтой асуудлуудтай тулгарч байна. Энэ нөхцөлд хатуу гар бүхий авторитар дэглэм тоглоом түүний хүч нөлөө, хөшүүргээр эдийн засгийн хямрал, нийгмийн дэг журам алдагдаж гэмт хэрэг өсч замбараагүй бай-

* А. Жамбал. — ШУА-ийн философи, социологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

дал үргэлжилж байгааг арилган зогсоож болно гэж үздэг хүмүүс цөөнгүй, мөн тийм үзэл баримжаатай улс төрийн зарим хүч ч байна. Энэ нь авторитар дэглэмийн асуудал манай орны улс төрийн амьдралтай ямар нэг байдлаар холбоо хамааралтай байгаа гэсэн үг. Үүнтэй уялдаж улс төрийн авторитари дэглэмийн уг шинж, мөн чанар үүрэг зорилго, түүхэн туршлага, сургамж сангуулга зэрэг олон чухал асуудлыг энэ дэглэм урьд өмнө тогтон ноёрхож байсан, одоо эл дэглэм тогтож буй дэлхийн янз бүрийн улс орны туршлага, жишээ баримтанд тулгуурлаж судлан шинжлэх, нэгтгэн дүгнэх явдал чухал юм.

Манайд улс төрийн дэглэм, түүний үндсэн хэлбэрүүд болох ардчилсан дэглэм, тоталитар ба авторитар дэглэмийн талаар олонтаа ярьж эдгээр ойлголт томъёоллуудыг янз бүрийн утга зохиолд өргөн хэрэглэж байгаа боловч тэдгээр дэглэмүүдийн асуудлыг зохих ёсоор судлан боловсруулаагүй байна.

Авторитар дэглэмийг судлахдаа нэн түрүүнд улс төрийн дэглэм хэмээх ерөнхий ойлголтын утга агуулгыг тодруулан гаргаж томъёолох явдал арга зүйн хувьд чухал ач холбогдолтой болно. Марксист үзэл чиглэлтэй төр эрхийн уламжлалт онолд улс төрийн дэглэм хэмээх ойлголтыг төдийлөн хэрэглэдэггүй, түүнийг ихэвчлэн төрийн ба засаглалын хэлбэр, төрийн байгууламжийн хэлбэр гэх зэрэг ойлголтын хүрээнд явцуу утгаар ойлгож иржээ. Гэтэл дэлхий нийтийн ялангуяа барууны улс төр судлал, улс төрийн гүн ухаанд улс төрийн дэглэм бол нийгмийн улс төрийн амьдралын бие даасан өвөрмөц, томоохон үзэгдэл мөн бөгөөд энэ үзэгдлийг илэрхийлж тусгасан улс төрийн дэглэм хэмээх ойлголт нь онол, танин мэдэхүй, судалгааны арга зүй, хандлагын хувьд өөрийн өвөрмөц утга агуулга, ачаалал үүрэгтэй хэмээн үздэг байна. Оршодийн улс төр судлагчид энэ дагуу улс төрийн дэглэмийн онол-арга зүйн ерөнхий асуудал хийгээд тоталитар болон авторитар дэглэмийн талаар олон жилийн туршид судалгаа хийж өч төчнөөн ном бүтээл хэвлүүлжээ.

Товч бөгөөд ерөнхий байдлаар илэрхийлвэл улс төрийн дэглэм бол нийгэмд улс төрийн засаглалыг хэрэгжүүлэх арга, зарчим, хэрэгслүүдийн цогцолбор тогтолцоо мөн болно. Улс төрийн дэглэм аль нэг тодорхой хэлбэрээр тогтож ноёрхоход тухайн улс орны эдийн засгийн хөгжлийн түвшин, нийгэм-улс төрийн харилцаа, улс төрийн хүчнүүдийн харьцаа, төрийн засаглалын зохион байгуулж хэрэгжүүлж ирсэн уламжлал, хүн амын ерөнхий болон улс төрийн соёлын түвшин, шинж, онцлог зэрэг бодит нөхцөл байдал, хүчин зүйлс нөлөөлж нөхцөлдүүлнэ. Улс төрийн дэглэм төрийн засаглал ба иргэний нийгэм, түүний анги, давхраа хэсэг бүлэг, хувь хүмүүсийн хоорондын улс төрийн харилцааны төлөв байдал, нийгэмд үйлчилж буй улс төрийн хэм хэмжээ, хамгийн гол нь тухайн орон дахь улс төрийн ардчилал, эрх чөлөө, хүний эрх, тэр орны улс төрийн ерөнхий шинж, дүр төрхийг илэрхийлж харуулна.

Авторитар дэглэм бол улс төрийн дэглэмийн үндсэн түүхэн томоохон хэлбэрийн нэг мөн болно. Эл дэглэм хүн төрөлхтний улс төрийн түүхэнд аль эртнээс ноёрхож янз бүрийн хэлбэртэйгээр хувьсан өөрчлөгдөж өдгөөг хүрчээ. Авто-

ритари дэглэмийн түүхэн тодорхой хэлбэрүүд бол эртний боол эзэмшлийн болон дундад зууны феодализмын үеийн дарангуй төр, ялангуяа дорно дахин, азийн хэрцгий засаг төр, хэмжээгүй эрхт хаант засаг, шинэ үе ба орчин үеийн цагдаа, цэргийн эрхтний дарангуй дэглэм гэх зэрэг болно. Зарим ном бүтээлд авторитаризм ба тоталитаризм хоёрыг адилтгаж нэг төрөл хэлбэрийн дэглэм мэтээр авч үзсэн нь ташаарсан зүйл юм. Энэ хоёр дэглэм хоёулаа ардчилал, хүний эрх, эрх чөлөө, тэгш байдал шударга ёсонд харш дарангуй дэглэм мөнөөрөө хоорондоо ижил төстэй боловч зарчмын ялгаатай. Зөвхөн цаг хугацааны хувьд, түүхэн үүднээс авч үзэхэд тоталитар дэглэм нь чухамдаа ХХ зууны үзэгдэл болж хожуу гарч ирсэн байх жишээтэй.

Авторитар дэглэмийн урт удаан хувьсал, түүхэн тодорхой хэлбэрүүдийг түүхчилж авч үзэх нь тусгай судалгаа шаардах нарийн зорилт болох нь тодорхой. Тиймээс бид эл асуудлыг хөндөлгүй орхиж орчин үеийн авторитар дэглэмийн талаар өгүүлэхийг зорьсон болно.

Авторитаризм, авторитор дэглэм хэмээх нэр томъёо нь хэл зүйн хувьд латин хэлний засаглал, нөлөөлөл гэсэн утга санааг илэрхийлсэн гэсэн үгнээс гарал үүсэлтэй. Авторитар ёс бол ер нь засаглал, улс төрийн бодлого, удирдлагад зохих хэмжээгээр угаасаа байдаг бодит шинж чанар ажээ. Засаглал улс төрийн бодлого, удирдлагыг нийгэмд хэрэгжүүлэхдээ тэдгээрийн дээд эрх мэдэл, хүч нөлөөг нэг төвд, нэг гарт тодорхой хэмжээгээр төвлөрүүлж эзэн хаан, ерөнхийлөгч, ерөнхий сайд, парламент, эсвэл онцгой тохиолдолд цэргийн дээд эрх тушаалтнаар төлөөлүүлж хэрэгжүүлэхээс өөр аргагүй тохиолдол байдаг. Засаглал, улс төрийн бодлого, удирдлага нь захирах захирагдах харилцааг зайлшгүй шаардана. Иргэний нийгэм нэг талаас ардчилсан, хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэж бодитойгоор хэрэгжүүлсэн, нөгөө талаас эмх цэгцтэй, дэг журамтай, иргэд нь хариуцлага сахилга баттай байж аж төрж хөдөлмөрлөн бүтээх явдалд үндэслэж тулгуурлах учиртай. Үүний тулд засаглал, улс төрийн бодлого дахь авторитар ёсны хэв хэмжээ захирах захирагдах харилцаа «алтан дундажийн» хэр хэмжээнд хүч тэнцүү байвал зохино. Тэгэхдээ засаглал дахь авторитар ёсны элемент, захиргаа, албадлага, хүчирхийллийн хэр хэмжээ эрх баригчийн дур зорго, хүссэн санаснаар биш, харин нийгэм олон нийтийн эрх ашиг, хүсэл зоригийн дагуу хууль эрхийн үндэстэйгээр тогтоогдсон байх ёстой. Хэрэв засаглал дахь захирах захирагдах харилцааны тэнцвэрт харьцаа алдагдаж авторитор ёсны элемент, шинж, захирах харилцаа давамгайлж ноёрхвол ардчилсан дэглэм алдагдаж авторитаризм буюу засаглалын дээд эрх мэдэл, хүч нөлөө, хөшүүрэг нэг хүн, эсвэл цөөхөн этгээд, хэсэг бүлгийн гарт төвлөрч хууль эрхийн хүрээ хяналтаас гарч дарангуй дэглэм тогтооход хүрнэ. Нөгөө талаас засаглалын авторитар элемент, захирах харилцаа эсрэгээр сулран алдагдаж засаглал нийгмийн үүрэг гүйцэтгэж чадахаа боливол өөр нэг туйлшрал буюу нийгмийн эмх замбараагүй байдал, анархизм, хариуцлага сахилга батгүй явдал үүсэж нийгэмд авторитаризмаас дутуугүй хор хохирол учруулна. Энэ бол нийгэмд засаглалыг хэрэгжүүлэх явцад авторитар дэглэм үүсэж гарах, тогтож ноёрхох бололцоо зай

чөлөө ямар нэг хэмжээгээр угаасаа байдаг, мөн явц дундаа үүсэж бий болдоггүйг харуулж байгаа баримт юм.

Авторитар дэглэмийн онцлог, гол, чухал шинж чанаруудыг дараах байдлаар ангилан илэрхийлж болно. Нэгдүгээрт, энэ дэглэмийн нөхцөлд төрийн засаглалын дээд эрх мэдэл хүч хөшүүрэг нь дарангуйлан захирагч нэг хүн, тухайлбал ерөнхийлөгч, эзэн хаан, ерөнхий сайд, эсвэл төрийн эргэлт хийсэн цэргийн жанжлагч юм уу эсвэл улс төрийн засаглалын нэг байгууллага, аппарат түүнчлэн цөөн тооны хэсэг бүлгийн гарт төвлөрсөн байдаг. Хоёрдугаарт, тэдний энэхүү дээд эрх мэдэл нь хууль ёс, эрх зүйгээр хязгаарлагдаагүй, иргэний нийгэм, олон нийтийн хяналтаас гарсан байна. Зарим тохиолдолд дарангуйлагч этгээд авторитар дэглэмийг хууль ёс эрх зүйн дагуу тогтоож хэрэгжүүлдэг туршлага байдаг хэдий боловч тэр нь ард олны эрх ашиг, хүсэл зоригийн дагуу тэдний өөрсдийнх нь оролцоотойгоор тогтоогдсон биш, харин засаглан дарангуйлагчдын зүгээс нийгэмд хүчээр тулган хүлээлгэж тогтоосон шинжтэй байдаг. Энэ утгаараа авторитар дэглэмийн төр бол жинхэнэ эрх зүйт төр байдаггүй, эл дэглэмийн зүгээс тогтоож тунхагласан үндсэн хууль, хууль ёс, эрх зүй нь хэлбэр төдий уг хатуу дэглэмийг халхлан нууж далдалсан, олон нийт, гадаад улс орнуудын үзэл төсөөлөл, сэтгэл зүйг төөрөгдүүлсэн үзэл суртал, сэтгэл зүйн баг бамбай байдаг. Гуравдугаарт авторитар дэглэмийн зүгээс нийгмийг удирдан жолоодож засаглахдаа захиран тушаах арга, албадах, хүч хэрэглэх арга ажиллагаанд голлон тулгуурлана. Гэхдээ авторитар дэглэм тоталитар дэглэм шиг хүн ард, нийгмийн хэсэг бүлэг, давхрааг тэр бүр хатуу харгисаар залхаан цээрлүүлж хэлмэгдүүлдэггүй ч гэсэн шаардлагатай тохиолдолд хүч хэрэглэдэг, тийм хүч хүчирхкнйлэлийг бэлэн байдалтай байлгаж түүнийгээ иргэд, хүн ардаас нуудаггүй. Дөрөвдүгээрт, авторитар дэглэмийн улс төрийн хамгийн гол, чухал шинж бол тэрээр улс төрийн засаглал, түүний дээд мэдэл эрх мэдэл, аппарат, хэрэгслийг нэг хүн буюу хэсэг бүлэг этгээд халаа солиогүй монополчилан эзэмшиж улс төрийн сөрөг хүч, нам, эвсэл холбоо, хөдөлгөөнийг цагдаж хориглодог. Хэрэв улс төрийн тийм хүч, нам бусад байгууллагын оршин тогтнол, үйл ажиллагааг хүлээн зөвшөөрвөл тухайн дэглэмийн хүрээнд, түүний хатуу хараа хяналт, ноёрхлын доор зөвшөөрч хязгаарлан барина. Энэ нөхцөлд албан ёсны авторитар дэглэмтэй жинхэнэ ёсоор сөргөлдөх түүнтэй тэмцэлдэн өрсөлдөх улс төрийн бодит хүч байх аргагүй байдаг. Засаг төрийн дээд эрх мэдлийг халаа солиогүй дангаар эзэмшиж ноёрхсон улс төрийн дарангуй элит бүрэлдэж бий болно. Энэ элитийн бүлэг нь явцуу, хаалттай байх ба эгнээ бүрэлдэхүүнээ дотроосоо сэлбэнэ. Засаг төрийн өндөр дээд албан тушаал, бусад чухал пост өндөрлөгүүдийг өөрийнхөө хүрээний хүмүүст төрөл садан, үйл хэрэг, санаа зорилго нэгтэй эсэхээр нь шалгаруулж өвлүүлж эдлүүлнэ. Үүнтэй уялдаж авторитар дэглэмийн үед тухайн улс орны нийгэм-эдний засаг, улс төр үзэл суртлын амин чухал асуудал, зорилтуудыг улс төрийн янз бүрийн хүч, өргөн олон түмний оролцоотойгоор ардчилсан арга барил, зарчмын дагуу шийдвэрлэх бололцоо, арга зам хэрэг дээрээ байдаггүй. Тавдугаарт авторитар дэглэмийн чухал онцлогтой шинж бол

тэрээр хэдийгээр улс төрийн ардчилал, эрх чөлөө, хүний эрх, нийгмийн шударга ёс журамд харш, эсрэг шинжтэй дэглэм байдаг боловч туйлын хатуу харгис дарангуй дэглэм болох тоталитар дэглэмээс нэг зүйлээр зарчмын ялгаатай болно. Хэрэв тоталитар дэглэм нийгмийн амьдралын бүх хүрээ салбарыг тэр дотроо хүмүүсийн хувийн амьдрал, аж төрөх ёс тэдний үзэл бодол, санаа зоригийг хүртэл хатуу хянаж, мөрдөн мөшгөж, эдийн засаг, өмч хөрөнгийг төрийн хяналт, этганд байлгаж эдийн засгийн эрх чөлөөг боогдуулан барьдаг бол харин авторитар дэглэм нийгмийн хүрээ, эдийн засгийн харьцангуйгаар чөлөөтэй байлгаж өмчийн олон хэлбэрийг, тухайлбал хувийн өмчийг хүлээн зөвшөөрнө. Авторитар дэглэм гол нь улс төрийн засаглалын монополь эрх аюулгүй байдлыг хангах, иргэний нийгэм, улс төрийн хүчнүүдийн зүгээс засаглал, төрийн эрх мэдлийн төлөө үүсэж болох тэмцэл, аливаа санаархал, халдлагаас болгоомжлох сэрэмжлүүлэхэд илүү их анхаарал хандуулдаг онцлогтой. Энэ нь авторитар дэглэмийн нөхцөлд иргэний нийгмийн бие даасан, тайван тогтвортой байдал тодорхой хэмжээгээр хадгалагдах нөхцөл бололцоог бий болгоно. Энэ байдал эргэж авторитар дэглэм тухайн улс оронд нийгмийн зүгээс ноцтой ширүүн эсэргүүцэл тэмцэлтэй тулгарахгүйгээр харьцангуй удаан, тогтвортой оршин тогтноход чөлөөлнө.

Авторитар дэглэм ямар улс оронд хэрхэн яаж бүрэлдэн тогтдог вэ? XX зууны II хагаст энэ дэглэм тогтож ноёрхсон дэлхийн янз бүрийн тив, бүс нутгийн орнуудын туршлага, жишээ баримтаас үзэхэд энэ дэглэм голдуу нийгмийн нэг байгууллагаас өөр байгуулалд шилжих шилжилтийн үед, эдийн засаг, нийгмийн хөгжил буурай дорой, улс төрийн тогтворгүй байдалтай орнуудад тогтсон байна. Тийм орнуудад нийгмийн хуучин уламжлалт байгуулал, эдийн засаг аж ахуй, техник технологи, улс төрийн тогтолцоо, соёл, үнэт зүйлсийн тогтолцоо өөрийнхөө урьдын бололцоо, үр өгөөжөө шавхаж тэдгээрийг орчин үед тохирсон зүй зохистой болгож шинэчлэх ялангуяа эдийн засгийн хоцрогдол, ядуурал, нийгмийн бусад хурц, тулгамдсан зорилтыг даруй шийдвэрлэх зорилт тавигддаг ажээ.

Эдийн засаг, нийгмийн тийм нөхцөл байдалтай орнуудад улс төрийн байдал тогтворгүй, нийгмийн давхраа, улс төрийн хүчнүүдийн хооронд янз бүрийн тэмцэл сөргөлдөөн байнга үүсэн хурцаддаг, энэ нь эргэж нийгмийн хөгжил дэвшилд, тэр тусмаа эдийн засагт сүрхий саад бэрхшээл болдог байна. Тийм ноцтой байдал зарим улс оронд цааш нь даамжрал гүнзгийрч иргэний дайн гарах, улс орны тусгаар тогтнол, үндэсний нэгдэл нягтрал, бүрэн бүтэн байдлыг задлан буснуулах аюул учруулдаг тохиолдол ч гарч байжээ. Ийм нөхцөлд нийгмийг модернизаци хийх замаар өөрчлөн шинэчлэх, ялангуяа эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудал, зорилтуудыг шийдвэрлэх улс орны нэгдэл нягтрал, бүрэн бүтэн байдал, тусгаар тогтнолыг хадгалан хамгаалж үлдэх үүднээс улс төрийн эрх чөлөө хүний эрх, ардчилалтыг хүчээр хязгаарлан хүмийж, засаглалыг чангалж төвлөрсөн удирдлага ноёрхол бүхий авторитар дэглэм тогтоох шаардлага гардаг байна. Энэ бол авторитар дэглэм бүрэлдэн тогтох бодит шалтгаан, нөхцөл болдог. Дэлхийн II дайны дараах үед Өмнөд Солонгос, Тайвань, Филиппин, Ма-

лайз, Тайланд, Сингапур, Ингер, 70-аад оны үед Чили, мөн Латин Америкийн хэд хэдэн оронд нийгэм-эдийн засаг, улс төрийн шинэчлэл, модернизаци хийх, эдийн засгийн хямрал, техник, технологийн хоцрогдлыг даван туулах, улс төрийн тэмцэл сөргөлдөөн, тогтворгүй байдлыг арилгах зорилгоор засаглал, удирдлагыг төвлөрүүлэн чангалж авторитар дэглэм тогтоосон бөгөөд энэ нь ч зохих үр дүнгээ өгчээ.

Гэтэл авторитар дэглэмийг практикийн хувьд эсэргүүцэн тэмцдэг улс төрийн сөрөг хүч, онол, үзэл суртлын үүднээс шүүмжлэн няцаадаг улс төр судлагчид нийгмийн шинэтгэл хийх, эдийн засаг, нийгэм, соёлын тулгамдсан зорилтуудыг улс төрийн ардчиллыг хязгаарлан хумихгүйгээр, өөрөөр хэлбэл авторитар дэглэм тогтоохгүйгээр тайван байдлаар, ардчилсан арга замаар шийдвэрлэж болно гэж үздэг. Энэ хандлага, үзлийг үгүйсгэх аргагүй. Ардчилал ардчилсан дэглэм нь хүмүүсийн эрх, эрх чөлөөг хангаж тэдний идэвхтэй бүтээлч үйл ажиллагааг орнүүлэх, нийгэм-улс төрийн үйл ажиллагаандаа чөлөөтэй сонголт хийх бололцоог бүрдүүлдэгээрээ нийгэм-эдийн засгийн зорилт, асуудлыг шийдвэрлэхэд эргэж тус дөхөм болно. Гэхдээ ардчилал, хүний эрх эрх чөлөө бол хэдийгээр түгээмэл үнэт зүйл боловч тэдгээр нь бодит байдал дээр хэрэгжиж биелэхдээ тухайн улс орны түүхэн тодорхой нөхцөл байдал, онцлог, эдийн засаг, нийгмийн хөгжлийн түвшин, улс төрийн уламжлал, хүн ардын соёл боловсрол, аж төрөх ёсны шинж чанартай нөхцөлдөн холбогдож ямагт түүхэн тодорхой шинж, төлөв байдалтай байдаг. Өөрөөр хэлбэл ардчилал, ардчилсан дэглэм бол нийгэм, эдийн засаг, улс төрийн бүх асуудал, зорилтыг шийдвэрлэх бэлэн зэлэн, түгээмэл хэрэгсэл хараахан бишээ. Нийгэм, эдийн засаг, соёлын буурай, доогуур түвшин, хямрал, улс төрийн тэмцэл сөргөлдөөн, тэдгээрийг дагалдсан нийгмийн тогтвортой байдал нь ардчилал, хүний эрх, эрх чөлөөний үндэс суурь болдоггүй, харин ч улс төрийн хатуу дарангуй дэглэм үүсэн тогтох үндэс шалтгаан болдог нь түүхэнд зонхилж байжээ. Ардчилал, ардчилсан дэглэм нь чухамдаа нийгэм, эдийн засаг, соёл, улс төрийн харилцааны харьцангуй өндөр, боловсронгуй түвшинд, нийгмийн амьдралын тогтвортой хэвийн нөхцөлд өөрийнхөө хүмүүнлэг шинж агуулга, бүтээлч, идэвхтэй хүч бололцоогоо дэлгэж хэрэгжүүлдэг байна.

Аль нэг улс оронд авторитар дэглэм бүрэлдэн тогтоход тухайн орны улс төрийн амьдралын түүх, уламжлал, ард олны улс төрийн ухамсар, соёл, сэтгэл зүй багагүй нөлөөлдөг ажээ. Авторитар дэглэм чухамдаа Европын хөгжилтэй ардчиллын уламжлалтай улс орнуудад биш харин Ази, Африк, Латин Америкийн буурай хөгжилтэй орнуудад, өнгөрсөн түүхэндээ боолчил, хамжлагат ёс, хэмжээгүй эрхт хаант засгийн төрт ёс голлосон, капитализм сул хөгжсөн, ардчилал, парламент, ёс, олон намын тогтолцооны уламжлал сул, хүн амын ихэнх хэсэг нь тариачид, нийгмийн бусад жижиг дэвхрээнаас бүрэлдсэн, нийгмийн хэлхээ холбоонд отог овгийн харилцаа холбоо, уламжлал нөлөөтэй, хүмүүсийн улс төрийн ухамсар нь сэрж өсөөгүй, сэтгэл зүйн хувьд хүлцэнгүй тийм улс орнуудад зонхилж тогтож байсан явдал санамсаргүй тохиолдол биш юм.

Авторитар дэглэм эдийн засаг, нийгэм, улс төрийн дээр дурьдсан бодит нөхцөл байдалтай холбоотойгоор бүрэлдэн тогтодог нь олон орны бодит туршлага, жишээ баримт мөн боловч

түүнийг түгээмэл шинжтэй зүй тогтолт үзэгдэл гэж дүгнэн үзвэл учир дутагдалтай, туйлширсан хэрэг болно. Учир нь авторитар дэглэм ба эдийн засгийн хоцрогдол, нийгмийн ядуу буурай байдлын хооронд хатуу тогтсон нэг чиглэл хандлагатай шууд холбоо хамаарал байхгүй, энэ дэглэм бүрэлдэн тогтоход объектив бодит нөхцөлөөс гадна идэвхитэй субъектив хүчин зүйлийн үйлчлэл шаардагдана.

Авторитар дэглэм тогтоход нөлөөлөх субъектив хүчин гэвэл юуны өмнө энэ дэглэм өөрийнх нь сонирхол, эрх ашигт нийцэж тохирсон улс төрийн тодорхой хүч, тухайлбал эзэрхэг түрэмгий хэсэг бүлэг этгээд, тийм цөөнх хүчинд түшиглэсэн тодорхой бие хүн бүхий дарангуйлагч, төрийн эргэлд хийсэн цэргийн жанжлагч эрхтэн, төдний дарангуй, хүчирхий бодлого мөн болно. Улс төрийн эдгээр хүчин субъектууд авторитар дэглэм тогтоох гэж оролдон чармайхдаа, эсвэл хүчээр тогтоосны дараа түүнийг зөвтгөж нийгэм, хүн амаар хүлээн зөвшөөрүүлж албан ёсны болгож баталгаажуулах зорилгоор цэрэг-улс төр, зохион байгуулалтын идэвхтэй бодлого, суртал нэвтрүүлэг, сэтгэл зүйн үйл ажиллагаа явуулна. Юуны өмнө эл дэглэмийг эсэргүүцэгчдийг арми, цагдаа зэрэг төрийн хүч аппаратыг ашиглаж залхаан цээрлүүлж дарж няцаана. Тухайн улс орон, үндэстэн, ард олныг эдийн засгийн хоцрогдол, хямралаас гаргах, нийгэм-улс төрийн тулгамдсан хурц асуудлуудыг шийдвэрлэх бодит хэрэгцээ шаардлагыг дарангуй хүчнийхэн хувийн явцуу ашиг сонирхол, ноёрхлынхоо зорилгоор урвуулж овжин ашиглана. Энэ дагуу улс орон, нийт үндэстний эрх ашгийн тусын тулд улс төрийн ардчилал, хүний эрх, эрх чөлөөг хязгаарлаж засаглалыг нэг гарт төвлөрүүлэн чангалж түүнийг эдийн засаг, нийгмийн асуудал, зорилтыг шийдвэрлэхэд чиглүүлэх шаардлагатай хэмээн үзэл суртлын үүднээс үндэслэж ухуулан сурталчилна. Тийнхүү авторитар дэглэмийг зөвтгөсөн улс төрийн үзэл суртал, номлол, уриа лоозон, эрхэмлэл зорилго гарч ирдэг байна. Авторитар дэглэм тогтоогч хүчнийхэн өөрсдийнхөө эзэрхэг дэглэмийг олон нийтээр хүлээн зөвшөөрүүлж хуульчилан баталгаажуулахдаа тухайн нийгэм, үндэстний ухамсар, сэтгэл зүй, уламжлалыг сүрхий анхааран үзэж овжин ашигладаг ажээ. Ялангуяа засаглал, төрийг үзэх патерналист, уламжлалт үзэл ухамсар, сэтгэл зүй нь авторитар, дарангуй дэглэм тогтоож, ноёрхоход үзэл санааны хувьд тааламжтайгаар нөлөөлдөг байна. Төр, засаглалыг үзэх патерналист үзэл нь эзэн хаан, улсын ерөнхийлөгч, ерөнхий сайд, дарангуйлагчийн хэнийг нь ч бай улс гэрийн удирдагч, эзэн, олон түмнийг өмгөөлөн хамгаалагч эцэг хэмээн ойлгож ард олон түүнд үг дуугүй захирагдах ёстой хэмээн үздэг нь авторитар дэглэм тогтоогчид өөрсдийгөө өмгөөлж хамгаалахад тун тохиромжтой үзэл суртал байдаг.

Авторитар дэглэмийг тогтоогчид нийгэм, үндэстэн, ард олны өмнө тулгаран тавигдсан эдийн засаг, нийгэм, улс төрийн хурц төвөг бэрхшээлтэй зорилт, асуудлыг ардчилал, ардчилсан дэглэмийн арга хүчээр шийдвэрлэх боломжгүй, ер нь нийгмийн шинэчлэл, модернизацийн эгзэгтэй, огцом эргэлтийн үед тулгамдсан зорилтыг хатуу гар, төвлөрсөн хүчтэй засаглалаар л шийдвэрлэж болно. Үүний тулд ардчилалыг «түр» хойш нь тавьж хумилж хязгаарлах шаардлагатай гэж үздэг.

Авторитар дэглэмийн үзэл номлол нь нийгмийн амьдралын эргэлтийн шинжтэй, хямралтай үед ардчилал, хүний эрх, эрх чөлөө бол нийгмийн тогтворгүй байдлыг улам гүнзгийрүүлж, эмх замбараагүй, дэглэм журамгүй байдалд хүргэж, улс орон, үндэстэнг сүйрэл бутрал, сарнилд аваачина хэмээн номлодог. Энэ нь тодорхой тохиолдолд үнэний хувьтай байдгийг үгүйсгэх аргагүй. Тэгэхдээ асуудлын гол нь тухайн оронд авторитар дэглэм тогтоох замаар шийдвэрлэх шаардлагатай юу үгүй юу гэдгийг бодитойгоор, үнэн зөвөөр тогтоож үнэлэхдээ байгаа юм. Ер нь авторитар дэглэм нийгэм-улс төрийн аливаа үзэгдлийн нэгэн адил өөрөө зөрчилтэй, сөрөг ба зөрэг шинжтэй үзэгдэл ажээ. Тийм учраас эл дэглэмийн нийгэм-улс төр, эдийн засгийн үүрэг, утга учир, хор уршиг, сөрөг талыг нэг үзүүлэлт шалгуураар, нэг утгатайгаар үнэлэн дүгнэх явдал өрөөсгөл, учир дутагдалтай болно. Тухайлбал авторитар дэглэм тодорхой нөхцөл, тохиолдолд тухайн улс орон, ард түмнийг нийгмийн хямрал, иргэний дайн, үймээн самуун, замбараагүй байдал зэрэг бодит аюул, сүйрлээс авраг гаргах гарцаагүй сонголт, арга зам байж болно. Мөн үр дүнгээ ч өгч тавьсан зорилтонд хүргэж болно, тийм туршлага ч бий. Энэ тохиолдолд эл дэглэмийн эдийн засаг, улс төрийн ач холбогдол, үр дүн гүйцэтгэсэн бодит үүргийг үгүйсгэх аргагүй. Гэхдээ энэ дэглэм тогтсон нөхцөлд ардчилал, хүний эрх, эрх чөлөө хумигдаж дарангуйлал, хэлмэгдүүлэлт гардагийг мартаж үл болно. Нийгмийг модернизаци хийж шинэчлэх зорилтыг аажим алгуур, ардчилсан дэглэмээр хэрэгжүүлэх бодитой бололцоотой, тийм нөхцөл бүрэлдсэн тохиолдолд улс төрийн дарангуй хүч гарч ирж тийм бололцоо, сонголтыг хүчээр үгүйсгэн зогсоож өөрсдийнхөө ноёрхол дэглэм, хүсэл зоригоо нийгэмд хүчээр тулган хүлээлгэж тогтоосон авторитар дэглэмийг хүмүүлэг, шударга ёс зарчим хийгээд нийгэм-эдийн засаг, улс төрийн прагматик ашгийн алины ч үүднээс зөвтгөх аргагүй. Тийм учраас аль нэг улс оронд тогтож ноёрхсон авторитар дэглэмийг түүний үүсэж тогтсон түүхэн тодорхой бодит нөхцөл байдал, субъектив хүчин зүйлтэй нь нягт холбоотойгоор авч үзэж түүхэн тодорхой хандаж үнэлэн дүгнэх шаардлагатай.

Авторитар дэглэм тогтоож түүний хүч нөлөөгөөр зохих үр дүн, зорилгод хүрсэн орнуудын туршлагаас үзэхэд эл дэглэм нийгмийг модернизаци хийж шинэчлэх, эдийн засаг, улс төр, удирдлага зохион байгуулалтын тулгамдсан асуудлыг үр ашигтай, оновчтой шийдвэрлэх хэрэгсэл, баталгаа болж чадах эсэх нь дараах зүйлээс шалтгаалдаг нь ажиглагдаж байна. Нэгдүгээрт, авторитар дэглэм тогтоосон толгойлогч нь өөрийнхөө хамтран зүтгэгч, холбоотон хүчийг цаашдаа хэвээр нь хадгалж бэхжүүлэх, сөрөг, тэмцэлдэгч тал, хүчнийкэнтэй ямар нэг хэлбэрээр тохиролцож зөвшилцөлд хүрэх, аль болохоор хүч хэрэглэхээс зайлсхийх, гэхдээ сөрөг хүчний аливаа эсэргүүцэл, шахалт дарамтанд автагдахгүйгээр зорилго, бодлогоо тууштай үргэлжлүүлж хэрэгжүүлэх шаардлагатай болно. Хоёрдугаарт, авторитар дэглэмийг хэрэгжүүлэхээр зорьсон модернизаци, нийгэм, эдийн засаг, улс төрийн зорилго нь нэгэн нэгдмэл, нэг чигтэй, тууштай байхын хамт мөн тодорхой цаг үе, нөхцөл байдлыг тооцож тусгасан тодорхой хэсэг, үе шаттай, түүнийг хэрэгжүүлэх харилцан ялгаатай хэрэгсэл, аргатай, товч хэлбэл уян хатан байх ёстой. Нийгмийг шинэчлэх тэдгээр үе

шат, хэсэгчилсэн зорилтууд тус бүртээ бодит үр дүнд хүрэх нь нэн чухал бөгөөд энэ нь нийгэм, олон нийтийн санаа бодол тайван байж тэд тухайн авторитар дэглэмийг хурц илрүүн эсэргүүцэхгүйгээр хүлээцтэй хандах таатай нөхцөл бүрэлдүүлдэг байна. Гуравдугаарт, авторитар дэглэм өөрийнхөө бодлого, үйл ажиллагаандаа тухайн улс орны түүхэн тодорхой нөхцөл байдал, цаг үеийн өөрчлөлт, улс төрийн хүчний харьцаа ард олон, үндэстний онцлог, гадаад харилцаа, олон улсын байдлын өөрчлөлтийн эерэг ба сөрөг нөлөө зэргийг бодитойгоор үнэлж тооцох ёстой ажээ.

Орчин үед Дэлхийн янз бүрийн оронд тогтсон авторитар дэглэмийн түүхэн өөрчлөлт, хувьсал, түүний чиглэл хандлагын тухай асуудал анхаарал татаж байна. Авторитар дэглэм тогтсон улс орнуудын туршлагаас үзэхэд энэ дэглэм урт удаан хугацаагаар хатуу хахираар оршиж нэг хэвээр хадгалагдахгүй, харин ч өөрийнхөө дотоод сурвалж хүч, үйл явдал, мөн олон улсын амьдралын өөрчлөлт, дэвшлийн нөлөөгөөр хувьсан өөрчлөгддөг чиг хандлагатай ажээ.

Авторитар дэглэм ялангуяа дэлхийн 2-р дайны дараах үеэс бүхэлдээ шилжилтийн шинж чанартай болсоор байна. Үүний учир шалтгаан нь авторитар дэглэмийн өөрийнх нь хүрэн дотор явагдах эдийн засаг, нийгэм-улс төрийн динамик өөрчлөлт, үйл явцтай холбоотой. Энэ дэглэм хэднйгээр улс төрийн засаглал, ноёрхлыг нэг гарт төвлөрүүлэн монополчилж дангаар эзэмшиж ардчилал, олон эшт үзэл суртлыг цагдан хориглодог боловч эдийн засгийн эрх чөлөө, өмчийн хувийн болон бусад хэлбэрийг чөлөөтэй байлгадаг онцлогтой. Эдийн засгийн амьдралын энэхүү чөлөөтэй өөрчлөлт хувьсал, хувийн өмчийн хэлбэр, хөгжлийг дагаж хүн амын амьдралын түвшин аажим дээшлэн сайжирч, нийгмийн бүтэц өөрчлөгдөн хувийн өмчинд тулгуурласан, жижиг дунд үйлдвэрлэл, газар тариалан, хөдөө аж ахуй эрхэлдэг дунд анги, хэсэг бүлэг гарч ирж нийгэмд зонхилох байр суурь эзэлдэг байна. Авторитар дэглэм төвлөрсөн удирдлага, хатуу гараар юуны өмнө эдийн засгийн хямрал бэрхшээл, техник технологийн хоцрогдлыг даван туулах, тэгснээрээ нийгэм улс төрийн тогтворгүй байдал, хурц сөргөлдөөн тэмцлийг намжаах, нийгэм хэвийн, тогтвортой оршиж хөгжих урьдач нөхцөлийг аяндаа бүрдүүлдэг ажээ. Үүний үр дүнд нийгмийн бүтэц, хүн амын зонхилох хувь нь эдийн засаг, өмчийн талаар бие дааж авторитар засаг төрөөс хараат бус байдалтай болдог. Эдийн засаг, өмч хөрөнгийн эрх чөлөөтэй, бие даасан хараат бус байдал нь улс төрийн эрх чөлөө, олон эшт үзэл суртал, ардчиллыг аяндаа шаарддаг байна. Авторитар дэглэм тогтоогч хүчнийхэн хэрэв өөрсдийнх нь улс төрийн ноёрхол, эрх ашигт хөндлөнгөөс онцын аюул занал учирахгүй байвал энэ хэрэгцээ шаардлагыг тооцон анхаарч, хэрэгжүүлэн биелүүлдэг, улс төрийн харилцаа, амьдралыг аажим алгуур ардчилах хандлага, бодлогыг баримталдаг байна. Авторитар дэглэм тогтсон дэлхийн ихэнх оронд эдийн засаг, нийгэм, улс төрийн үйл явдал, өөрчлөлт чухамдаа ийм чиглэл хандлагаар өрнөжээ. Тийнхүү авторитар дэглэм тодорхой хугацааны дараа хувьсан өөрчлөгдсөөр хатуу хахир дэглэмийн байдлаас ардчилсан дэглэмд шилжин орж хувьсдаг байна. Жишээлбэл: Ази, Латин Америкийн хэд хэдэн орны туршлагыг дурдаж болох юм. Үүнээс зөвхөн Тайваны жишээ баримт гэхэд энэ оронд

Гоминьданы улс төрийн авторитар дэглэм тогтоож ноёрхон захирах хугацаандаа улс орны өмнө тулгарсан хурц чухал асуудлуудыг юуны өмнө эдийн засгийг өөрчлөн шинэчлэх явдлаас эхэлж шийдвэрлэжээ. Улс төрийн амьдралд хатуу хяналт тавихын зэрэгцээ 1949 оноос газрын шинэчлэл хийх, газрыг тариачдад өгөх, гэхдээ газрын эздэд улсаас нөхөн төлбөр олгох, тэгснээрээ хөдөө аж ахуй, газар тариаланг урамшуулам хөгжүүлэх, жижиг бага үйлдвэрлэл, үйлчилгээг урамшуулах, улс орныг аж үйлдвэржүүлэх, экспортыг нэмэгдүүлэх зэрэг эдийн засгийн оновчтой, зөв бодлого явуулжээ. Эдийн засгийг тийнхүү либералчилж барууны орнуудтай олон талаар нээлттэйгээр харилцаж хамтран ажиллажээ. Энэ бүхний үр дүнд нийгмийн бүтэц өөрчлөгдөн дунд анги үүсэн бий болж тэд эдийн засаг, нийгэм-улс төрийн амьдралд чухал үүрэг гүйцэтгэх болжээ. Тайвань 1991 онд бараа экспортлох талаар дэлхийд 11-р байранд орж экспортын барааны 95,5%-ийг машин, цахилгааны бараа, металлургийн бүтээгдэхүүн зэрэг аж үйлдвэрийн бараа эзлэх болжээ. 1953 онд нэг хүнд үндэсний нийт бүтээгдэхүүн 1667 америк долларын хэмжээгээр оногдож байсан бол 1991 онд 8800 ам. доллар болж өсчээ. Энэ нөхцөлд эдийн засгийн хөгжил дэвшлээс улс орны удирдан зохиоход авторитари дэглэм, захиран тушаах арга илт хоцорч зөрчилдөх болсон ба улс төрийн амьдралыг ардчилах, хүний эрх, эрх чөлөөг хангаж хэрэгжүүлэх бодит хэрэгцээ шаардлага гарч иржээ. Энэ шаардлага аажим хэрэгжсэн байна. Юуны өмнө улс төрийн дэглэм, удирдлагын толгойлогч, түүний бүрэлдэхүүн өөрчлөгдөх болжээ. Улс төрийн засаглал, дэглэмийн толгойд 1950--60 оны үед үзэл суртал, улстөрийн бодлогыг гол болгож чухалчилсан хувьсгалч, намч, цэргийн эрхтэн, жанжлагч генералууд гарч байсан бол 1960-аад оны сүүлч үеэс хойш эдийн засаг, техник, технологийн хөгжил дэвшил, зүй зохистой удирдлага, зохион байгуулалтыг чухалчилан баримталсан технократууд голлох болжээ.

Эдийн засгийн эрх чөлөө, хувийн өмч, жижиг дунд үйлдвэрлэлийг эрхлэн тулгуурласан, хүний эрх, улс төрийн эрх чөлөөг эрхэмлэсэн барууны аж төрөх ёс, үнэт зүйлийг баримталсан дунд анги гарч ирж хүн амын зонхилох хувь хэсгийг эзэлж авторитар дэглэмд шахалт даралт үзүүлэн түүнийг хувьсган өөрчилж ардчилсан дэглэм бүрэлдэн тогтоход чухал нөлөө үзүүлэх болсон байна. Үүний үр дүнд Гоминьдан 1970-аад оноос хойш авторитар элитийн нам байснаа олон нийтийн нам болж хувирч эхэлжээ. Улс төрийн сөрөг хүч бий болж тэдний дарамт шахалтаар 1980 онд ил тод сонгууль явуулав. Мөн энэ үеэс эрх баригч нам улс төрийн бодлогодоо ардчиллыг дэмжиж олон нийтийн дэмжлэгийг хүлээх болжээ. 1986 онд улс төрийн шалтгаантай бослого, жагсаалт цуглааныг хориглосон хуулийг хүчингүй болгож чөлөөтэй болгожээ. 1987 онд онцгой байдлын хуулийг халжээ. Тайвань орон авторитар дэглэмээс ардчилсан дэглэмд эргэлт буцаалтгүйгээр шилжих явидаа байна.

Ийм жишээ туршилагыг Чили улсын хувьд мөн дурдаж болно. Харин энэ оронд Инночетийн авторитар дэглэм тогтсон үндэс шалтгаан бол засгийн эрхэнд коммунизмыг чиг баримжаа болгосон С. Аднениде тэргүүтэй зүүний хувьсгалч хүчний хэл гарч ирж бодлогоо хэрэгжүүлж эхэлснийг улс төрийн өөр

сөрөг бодлого, баримтлал бүхий хүчнийхэн таслан зогсоож засгийн эрхэнд гарсантай холбоотой.

Дэлхий нийтийн хэмжээнд авторитар дэглэм хувьсан өөрчлөгдөх үйл явц дап дэвшин урагшлах нэг чиглэлээр биш мөн гэдрэг эргэж ухрах, зөрчилтэй, ээдрээ бэрхшээлтэй байдлаар явагдаж байна.

Тухайлбал түүхийн хувьд зарим оронд тогтсон авторитар дэглэм цаашид өөрчлөгдөн хувьсахдаа ардчилсан дэглэмд биш харин коммунист тоталитар дэглэмд шилжин орсны жишээ баримт бол Куба улсад Ф. Кастро тэргүүтэй хүчнийхэн 1959 онд эхлээд авторитар дэглэм тогтоож тэр нь дотоод гадаадын нөлөө шалтгаан, хүчин зүйлийн эрхээр аажимдаа коммунист тоталитар дэглэм болж хувьссан явдал юм. Хуучин ЗХУ-ын их гүрний бүрэлдэхүүн хэсэг бүхий коммунист тоталитар дэглэмийн ноёрхолд байж энэ гүрэн задрахад тоталитаризмаас ардчилсан дэглэм рүү биш харин авторитар дэглэмд шилжин орж буй улс орнууд бол Казахстан, Тажикстан, мөн тодорхой байдлаар Туркменистаныг гэж хэлж болно.

Өнөөгийн Хятад орон 1970-аад оноос эхэлж коммунист тоталитар дэглэмээс аажим ангирах чиглэл баримжаатай болсон бөгөөд тэгэхдээ эрх баригч нэг намын улс төрийн хатуу засаглал, үзэл суртлын хяналт, ноёрхлыг хэвээр байлгаж харин эдийн засгийн амьдралыг чөлөөтэй болгож, зах зээлийн эдийн засаг, хувийн өмчийг хүлээн зөвшөөрснөөр хэрэг дээрээ тоталитар дэглэмээс авторитар дэглэмд шилжин оржээ. Хятад дахь авторитар дэглэм урьдын коммунист тоталитар дэглэмийн засаглалын зарим зарчим, арга хэрэгсэл, шинж чанарыг одоо ч хадгалж байгаа ба цаашдаа чухам хэрхэн яаж хувьсан өөрчлөгдөх нь төдийлөн тодорхойгүй байна.

Дүгнэж тэмдэглэхэд орчин үед улс төрийн авторитар дэглэм өөрийгөө хүчээр консерваци хийж нэг хэвээр хадгалах биш харин эдийн засаг, нийгэм, улс төрийн зүй зохистой хэрэгцээ шаардлагын дагуу аажмаар хувьсан өөрчлөгдөж ардчилал, нийгмийн хөгжил дэвшил, хүн төрөлхтний түгээмэл үнэт зүйл рүү чиглэн хувьсах хандлагатай болж байна. Энэхүү шилжилтийн үйл явц нийтлэг, зүй тогтолт шинжтэй болохын зэрэгцээ дотроо зөрчилтэй, хувьслын ерөнхий, урагшилсан чиглэл хандлагыг сөрж ухарсан үйл явдал ч гарч байна.

Авторитар ёс, авторитар дэглэм хүн төрөлхтөн, улс орнуудын орчин үеийн улс төрийн амьдралын бодит үзэгдэл, үйл явц хэвээр байна. Тиймээс ч түүнийг олон талаас нь судлан шинжилж онол, улс төрийн үнэлэлт дүгнэлт хийх, түүнийг улс төрийн бодлогод зүй зохистойгоор тусгаж анхаарах явдал дэлхийн хөгжиж буй, хөгжлийн шинэ сонголт хийж шилжилтийн

явцдаа байгаа орнуудын хувьд, тэр дотроо тоталитор дэглэм бүхий нийгмийн урьд өмнөх байгууллагаас ардчилсан, зах зээлийн эдийн засаг бүхий байгуулалд шилжих явцдаа байгаа Монгол орны хувьд сургамжтай, багагүй учир холбогдолтой болно.

1. Тоталитаризм, Монгол оронд тоталитар дэглэм тогтож ноёрхсон асуудлаар зохиогч дараах өгүүллүүдийг нийтлүүлсэн болно. Үүнд:

- А. Жамбал, Тоталитаризм. Гүн ухаан, нийгмийн сэтгэлгээ. УБ, 1991, № 1.

А. Жамбал. — Монгол оронд тоталитар дэглэм тогтож ноёрхсон зарим асуудал. — Дорно Өрнө сэтгүүл. УБ, 1993, № 2.

2. Энэ талаархи тоо баримтыг: — А. Ошикиенко, — Модернизация на Тайване: от экономической либерализации к политической демократии. — Мировая экономика и международные отношения—1993, № 2, Сэтгүүлээс ишлэл ав.